

Нэр томъёоны ижил нэрийн харьцуулсан судалгаа
(Монгол, Өвөр Монголын жишээн дээр)

САРАНГОЛ*

*БНХАУ, ӨМНШУХ-ийн Хэл судлах газар; Монгол Улс, Монгол улсын Боловсролын Их Сургуулийн
НХУС-ийн Монгол хэлний тэнхим*

Received: Oct 23, 2023

Revised: Nov 22, 2023

Accepted: Dec 15, 2023

Хураангуй: Нэр томъёоны тогтолцоонд ижил нэрийн хоёр төрөл байдаг. Нэгдүгээрт, нэг нэр томъёо өөр өөр салбарын ухагдахууныг тэмдэглэснийг шинжлэх ухааны салбар хоорондын ижил нэр гэнэ. Монгол хэлний үе, эд, үндэс, тойрог зэрэг олон үг шинжлэх ухааны янз бүрийн салбарын ухагдахууныг илэрхийлдэг. Хоёрдугаарт, утга зохиолын хэлний үгийн утгыг нэр томъёоны хүрээнд зүйрлэн шилжүүлж хэрэглэснээр ижил нэр үүсдэг. Монгол хэлний хамар, нүүдэл, тоорцог, хямрал, өнцөг зэрэг үгс нэр томъёо болжээ хэмээн О.Адьяа авч үзсэн буй. Өгүүлэлд, Монгол, Өвөр Монголд хэрэглэж байгаа нэр томъёонд ижил нэр томъёогоор адил бус ухагдахууныг илэрхийлэх үзэгдлийг нэр томъёоны ижил нэрийн төрөлд авч үзэж, түүний үүссэн шалтгааныг хоёр орны нэр томъёо оноон тогтоох зарчим, арга зүйн талаас тайлбарлах бөгөөд ингэхдээ тэдгээр ижил нэр нь нэг ухагдахууныг адил бус нэр томъёогоор илэрхийлэх үзэгдлийг үүсгэх гол сурвалж болохыг судлав.

Түлхүүр үг: нэр томъёо, ижил нэр, үгийн сан, ухагдахуун, утга зохиолын хэл, салбар шинжлэх ухаан

A Comparative Study on Some Homonymous Terms
(In the case of Mongolia and Inner Mongolia)

SARANGOL / LIUYUE

*Department of Language Studies of the Institute of Social Sciences of Inner Mongolia, Hohohot, China;
Department of Mongolian language, the School of Humanities and Social Sciences, Mongolian National
University of Education, Ulaanbaatar, Mongolia*

* © Liuyue / Сарангол
Email: sarengaole@163.com

Abstract: *There are two types of homonyms in the terminology system. First, interdisciplinary homonymy is when the same terminology designates different concepts from different fields. Many words in the Mongolian language, such as үе, эд, үндэс represent different concepts of various fields of science. Secondly, homonyms are formed by metaphorically transferring the meaning of literary language words into terminology. Several words in Mongolian, such as хамар, нүүдэл and онгоц, have become terms. Thirdly, the phenomenon of expressing different concepts with the same term and words used in Mongolia and Inner Mongolia will be considered and its reasons and etymology will be explained. Those homonyms will be considered in terms of term formation principles and methods.*

Keywords: *terminology, homonymy, lexicology, concept, literary language, scientific discipline*

1. Удиртгал

Монгол Улсад кирилл үсгийг нийтээрээ хэрэглэж, ӨМӨЗО-д монгол бичгийг өнөө хэр хэрэглэсээр байна. Хоёр улсын монголчууд хоёр өөр бичиг үсэг хэрэглээд наян жил өнгөрч байна. Монгол Улс болон Өвөр Монголын монголчууд хэдий нэг үндэстэн, нэг хэл аялгуу гэсэн ч хоёр өөр улс, хоёр өөр хэл соёлын орчинд байдаг учраас хоёр орны үгийн санд, ахуйн хийгээд салбар шинжлэх ухааны нэр томъёонд тодорхой хэмжээний ялгаа зөрөө оршиж байдаг.

Сүүлийн үед Монгол, Өвөр Монголд хэрэглэж байгаа нэр томъёонд гарч буй ялгаа зөрөөг эрдэмтэн судлаачид анхааралдаа авах болов. Ингэхдээ ихэвчлэн нэг ухагдахууныг адил бус нэр томъёо, үг хэллэгээр илэрхийлэх тухай судалгааны үр дүн давамгайлж байна. Бид Монгол, Өвөр Монголд хэрэглэж байгаа нэр томъёонд ижил нэр томъёогоор өөр өөр ухагдахууныг илэрхийлэх үзэгдлийг нэр томъёоны ижил нэрийн төрөлд авч үзэж судлах болно.

Монгол, Өвөр Монголд хэрэглэж байгаа нэр томъёоны ижил нэр нь хоёр оронд адил бус нэр томъёогоор нэг ухагдахууныг илэрхийлэх үзэгдлийг үүсгэх гол сурвалж болохыг тодруулахыг зорьсон бөгөөд энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

- Монгол, Өвөр Монголд хэрэглэж байгаа нэр томъёоноос ижил нэрийг түүвэрлэх;
- Монгол, Өвөр Монголд хэрэглэж байгаа нэр томъёоны ижил нэрийг хоёр оронд илэрхийлж байгаа агуулга, утгаар нь харьцуулан тайлбарлах;
- Монгол, Өвөр Монголд хэрэглэж байгаа нэр томъёоны ижил нэр үүссэн шалтгааныг тайлбарлах;
- Монгол, Өвөр Монголд хэрэглэж байгаа нэр томъёоны ижил нэр нь адил бус нэр томъёогоор нэг ухагдахууныг илэрхийлэх үзэгдлийг үүсгэх гол сурвалж болохыг тодруулах зэрэг болно.

Судалгааны практик ач холбогдол:

- Монгол, Өвөр Монголын орчин цагийн монгол хэлний үгийн сангийн нэр томьёонд ижил нэр байхыг илрүүлэх;
- Монгол, Өвөр Монголын орчин цагийн монгол хэлний үгийн сангийн нэр томьёонд ижил нэр ба адил бус нэрлэлтийг хооронд нь ялгах;
- Эдгээр ижил нэрээр шинжлэх ухааны салбарт түлхүүр нэр томьёо болгон тухайн салбарт адил бусаар нэрлэсэн нэр томьёог мөшгөн олох аргыг таниулахад оршино.

2. Судалгааны арга зүй

Энэхүү судалгаандаа *Монгол хэлний дэлгэрэнгүй их тайлбар толь*, *Монгол хэлний толь* (1999), *Шинжлэх ухааны түлхүүр нэр томьёоны тайлбар толь*-ийг хэрэглэгдэхүүн болгож ашиглав. Энэхүү судалгаа нь хам цагийн судалгаанд хамаарах бөгөөд баримт цуглуульж дүн шинжилгээ хийх, харьцуулах, задлан шинжлэх нэгтгэн дүгнэх зэрэг судалгааны аргыг хэрэглэв.

3. Ижил нэрийн тухай ерөнхий ойлголт

Орчин цагийн монгол хэлнээ *ижил үгс*, *ижил нэр* зэрэг ойлголтууд бий. Тодруулбал, орчин цагийн монгол хэлний үгсийн санд авианы бүрэлдэхүүнээрээ ижил, дуудлага болон бичлэг нь адилхан боловч өөр өөр утгатай үгсийн сангийн бие даасан нэгжүүд болох үгс нэлээд байдаг. Эдгээр үгсийг үгийн сангийн судлалд *ижил үгс* гэж нэрлэдэг. Ижил үгсийн үндсэн шинж бол хоёр буюу хэд хэдэн үгийн агуулгын тал нь ялгаатай боловч илэрхийлэх тал нь адил байдагт оршино (1990: 113). Тухайлбал, орой (орой болох), орой (уулны орой), угалз (аргаль угалз), угалз (хээ угалз), угалз (угалз босох), халах (халуунд халах), халах (халах солих), үр (үр тариа), үр (үр ашиг), үр (үр дүн) гэх мэт.

Түүнчлэн орчин цагийн монгол хэлний үгийн санд өөр өөр утгатай боловч дуудлагаараа адил үгс цөөнгүй бий. Ийм үгийг *ижил нэр* гэдэг. Жишээлбэл, ой (ой модны), ой (он жилийн), ой (оюун ухааны), сум (аймаг сумын), сум (буу зэвсгийн), гар (гарч одох), гар (хүний эрхтэн) гэх мэт. Дуудлага адил, утга өөр үгийг нэгэн үгийн салаа утга буюу үгийн утга зүйн хувилбараас ялгаж үзэх хэрэгтэй (Төмөрцэрэн, 2004: 48) аж.

Нэр томьёо бол үгийн сангийн нэлээд боловсорсон хэсэг болох бөгөөд соёл урлаг, улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн аль нэгэн салбарт тогтмол хэрэглэгдэх, оновчтой ухагдахуун илтгэсэн, гагц утга хадгалсан, зориуд боловсруулан зохиосон нэрийтгэл үгийг хэлдэг юм. Нэр томьёо нь хэрэглэгдэх аль нэгэн салбартаа тодорхой нэгэн утга илтгэж, үг найруулгын хувьд хязгаарлагдахгүй, ямар нэгэн санаа сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлэхгүй байдгийн дээр бас хоорондын тогтолцоот чанар нь маш нарийн байх шаардлагатай болно (Төмөрцэрэн, 2004: 184).

Түүнчлэн нэр томъёонд ижил нэр байх талаар эрдэмтэд бараг санал нэгтэй байдаг. Үгийн салаа утга холдсоноор нэр томъёоны ижил нэр үүсдэг хэмээн А.А.Реформатский, В.П.Даниленко, Н.П.Кузьмин, В.Н.Прохорова, И.С.Квитко, М.И.Фомина нарын ихэнх судлаач үзсэн байдаг. Нэр томъёоны тогтолцоонд ижил нэрийн хоёр төрөл байдаг. Үүнд: нэгдүгээрт, нэг нэр томъёо өөр өөр салбарын ухагдахууныг тэмдэглэснийг шинжлэх ухааны салбар хоорондын ижил нэр гэнэ. Жишээлбэл, *реакция*-г химийн ухаанд *урвал*, бие судлалд *харцу үйлдэл*, улс төрд *харгислал*; *редукция*-г авиа зүйд *балархайших*, хууль зүйд *хялбаршуулах*; *ассимиляция*-г авиа зүйд *ижилсэх*, угсаатны зүйд *уусах*, *морфология*-г байгалийн ухаанд *бүтэц зүй*, хэл шинжлэлд *үг зүй* гэх мэт.

Монгол хэлний *үе*, *эд*, *үндэс*, *тойрог* зэрэг олон үг шинжлэх ухааны янз бүрийн салбарын ухагдахууныг илэрхийлдэг билээ.

Хоёрдугаарт утга зохиолын хэлний үгийн утгыг нэр томъёоны хүрээнд зүйрлэн шилжүүлж хэрэглэснээр ижил нэр үүсдэгийн жишээ нь орос хэлний *гусеница*, *собачка*, *коза*, *лебеда*, *кошка*, *вилка*, *колени*, *кулачок* зэрэг нь монгол хэлний *хамар*, *нүүдэл*, *тоорцог*, *хямрал*, *өнцөг* зэрэг өдий төдий үг нэр томъёо болжээ.

Монгол хэлэнд ийм замаар үүссэн *чонын элэг*, *туулайн бөөр*, *үхрийн нүд*, *тэмээн хяруул* зэрэг нийлмэл нэр томъёо нэн элбэг байдаг нь энэ хэлний өвөрмөц онцлог юм.

Энэ мэтчилэн нэр томъёонд ижил нэр байх нь хэлний зүй тогтолт үзэгдлийн нэг юм. Дээр дурдсан нэр томъёоны гурван боть тольд 1184 буюу нийт үгийн 1.0 хувь нь ижил нэр байна (Адьяа, 2000: 15-16). Өөрөөр хэлбэл, дуудлага болон бичлэг нь адил боловч, өөр өөр шинжлэх ухааны салбарт өөр өөр ухагдахууныг илэрхийлдэг нэр томъёо байдаг. Ийм нэр томъёог салбар хоорондын ижил нэр гэдэг. Жишээлбэл, *үе* гэдэг нэр томъёо хэл шинжлэлд өгүүлэхийн эрхтнээс гарч буй хийн нэг түрэлтээр хэлэгдэх нэг юм уу хэд хэдэн авиаг заадаг бол бие судлалд, хүн, мал, амьтны яс хоорондын хөдөлгөөн бүхий холбоос, залгаа, нугалмай, уулзвар газар, ургамал судлалд, ургамлын ишийн түгдэрхий, бундгар газрыг заадаг. *Үндэс* гэдэг нэр томъёо хэл шинжлэлд үгийн үндсэн утга бүхий хэсэг буюу үг зүйн ёсоор янз бүрийн дагавар залгаж, цаашаа хувилгаж болох хэсэг бол ургамал судлалд, ургамлын газарт хавсан хэсэг (ургамлын шорооны дотор байж тогтоцтой болгон, ус чийг ба гэжээлийг залгуулах хэсэг). Түүнчлэн, утга зохиолын хэлний үгийн утгыг нэр томъёоны хүрээнд зүйрлэн нэрлэдэг. Жишээлбэл, *лууны нүд* нь утга зохиолын хэлэнд луу гэдэг домгийн амьтны харах эрхтнийг заадаг бол нэр томъёоны хүрээнд халуун орны нэгэн зүйлийн жимс, хавар зуны завсраар цэцэглэдэг бяцхан цэцэгтэй, намар жимс нь хонгорцоглон ургадаг, моголцог бөмбөг мэт хэлбэртэй, хатуу хальстай, модонд ургадаг, амт сайтай нэгэн зүйлийн жимс. Илжигний чих нь утга зохиолын хэлэнд илжиг гэдэг амьтны сонсох эрхтнийг заадаг бол нэр томъёоны хүрээнд модонд ургадаг, бөөрөнхийдүү хэлбэртэй, шар өнгөтэй, амтлаг жимсийг нэрлэдэг. Эдгээр үгийг утга зохиолын хэл болон нэр томъёоны хоорондын ижил нэр гэдэг. Бид

дараагийн хэсэгтээ Монгол, Өвөр Монголд хэрэглэж байгаа нэр томъёонд ижил нэр томъёогоор өөр өөр ухагдахууныг илэрхийлэх үзэгдлийг нэр томъёоны ижил нэрийн төрөлд авч үзэж судлах болно.

4. Монгол, Өвөр Монголын ижил нэрийн харьцуулсан судалгаа

Юуны өмнө Монгол, Өвөр Монголд хэрэглэж байгаа нэр томъёоноос нэг ухагдахууныг адил бус нэр томъёогоор илэрхийлэх тухай судалгааны үр дүнг авч үзнэ. Тухайлбал, хэл шинжлэлийн салбарын нэр томъёонуудын ялгаа зөрөөнөөс: *functional linguistics*-ыг Монголд *үүргийн хэл шинжлэл*, Өвөр Монголд *чадамжийн хэл шинжлэл*, *descending / falling tone*-ыг Монголд *уруудах хөг*, Өвөр Монголд *уруудах аялас*, *modal verbs*-ыг Монголд *баймж үйл үг*, Өвөр Монголд *хандлага үйл үг*, *syntactic function*-ыг Монголд *өгүүлбэр зүйн үүрэг*, Өвөр Монголд *өгүүлбэр зүйн чадамж*, *contextual meaning*-ыг Монголд *хам сэдвийн утга*, Өвөр Монголд *хэлний орчны утга* гэх мэтчилэн өөр өөрөөр нэрлэн хэрэглэж байна. Эдгээр нь салбар шинжлэх ухаан дотроо нэг ухагдахууныг адил бус нэр томъёогоор илэрхийлж байгаа үзэгдэл билээ. Хэл шинжлэлийн онолын өргөн хэрэглээний нэр томъёог нийт 1386-ыг харьцуулснаас тохирч байгаа нэр томъёо 1081 буюу 78%, төсөөтэй нэр томъёо 107 буюу 7.7%, зөрөөтэй нэр томъёо 198 буюу 14.3%-ыг тус тус эзэлж байна. Хоёр талын нэр томъёо боловсруулах арга зүй, орчуулан буулгах, оноон тогтоох туршлагаас шалтгаалан, зөрөөтэй зүйл гарсан байна. Англи болон хятад нэр томъёог утгачлан буулгахдаа монгол хэлнийхээ үгийн сангаас адил бус үгийг сонгон дүйлгэснээс зөрөөтэй нэр томъёо үүсжээ (Лю Юэ, 2020:167).

Энд бид Монгол, Өвөр Монголд хэрэглэж байгаа ижил нэр томъёо нь хоёр оронд адил бус ухагдахууныг илэрхийлэх үзэгдлийг авч үзнэ.

Салбар шинжлэх ухаан дотроо нэг нэр томъёогоор адил бус ухагдахууныг илэрхийлэх тохиолдол ажиглагдаж байна. Жишээлбэл, Монголд хэрэглэдэг *боловсрол* нь хувь хүний эзэмшсэн тогтолцоот мэдлэг, чадвар; мэргэжил мэдлэг эзэмшсэн нь(шинэ утга): *ерөнхий боловсрол*, *дээд боловсрол* г.м. Өвөр Монголд *боловсрол* гэдгээр боловсрох явдал (*цэргийн боловсрол*, *хичээлийн гаднах боловсрол* г.м.) хэмээх ойлголтыг илэрхийлдэг. Монголд *бичлэг* гэдэг үгээр бичгийн хэв, хэлбэр: *уран бичлэг*, *цэвэр бичлэг* гэхээс гадна дүрс дууны хэлбэлзлийг тусгай төхөөрөмжөөр хураан авсан нь (шинэ утга): *соронзон бичлэг* илэрхийлдэг бол Өвөр Монголд *бичлэг* хэмээх үгээр бичгийн хэв, хэлбэрийг (*зөв бичлэгийн дүрэм*, *бичлэгийн тиг* г.м) илэрхийлдэг билээ. Монголд *байцаах* хэмээх үгээр хянах, шалгах гэсэн утгыг илэрхийлдэг бол Өвөр Монголд *байцаалт* гэдгээр шинжилгээ хийх гэсэн утгаар ойлгож хэрэглэдэг, *хээрийн байцаалт хийх* гэвэл хээрийн шинжилгээ хийх. Монголд *найруулагч* хэмээх үгээр жүжиг киног зааварлаж дэглэн тоглуулагч (шинэ утга): *найруулагчийн төлөвлөгөө*, *ерөнхий найруулагч*, *кино найруулагч* (киноны зураг авалтыг удирдан зохион байгуулагч), *туслах найруулагч* зэргийг

илэрхийлдэг бол Өвөр Монголд *найруулагч* гэдгээр бичиг зохиол найруулах ажлыг тусгайлан эрхэлж байгаа хүн: *сонины найруулагч, сэтгүүлийн найруулагч* гэх мэтээр хэрэглэдэг.

Хоёр талын нэр томъёо боловсруулах арга зүй, оноон тогтоох зарчмаас шалтгаалан, зөрөөтэй зүйл гарсан байна. Бид хоёр орны нэр томъёо тогтооход баримталдаг зарчмаас авч үзье.

Монгол Улсад О.Адьяа нэр томъёо тогтоох зарчим ерөнхий хийгээд тусгай байдаг гэж үзжээ. Үүнд:

Нэр томъёог тухайн хэлний үгийн сангийн бүхэл цогц нэгж гэж үзвэл түүнийг тогтооход хэл бүхэнд мөрддөг (салбар ухааны нэр томъёог нарийн тогтолцоотой тогтоох, үг хураан товчилж шинэ нэр томъёо бүтээх, үг бүтэх ёсны хувьд зөв байх гэх мэт) ерөнхий зарчмыг баримтална. Тухайн хэлний нэр томъёог гарлын хувьд өөрийн хэлний, харь хэлний гэж хоёр хэсэг болгон хуваан үзвэл, түүнийг боловсруулах зарчим нь:

а) *Монголоор нэр томъёо тогтоох*

1. Монгол хэлэнд нэгэнт байсан уламжлалт үгсийг улируулан хэрэглэх;
2. Монгол хэлэнд нэгэнт байсан үгийг шинэ утгаар сэргээн хэрэглэх;
3. Шинэ үг зохиож нэр томъёо бий болгох;
4. Нэр томъёо бүтээхэд нутгийн аялгууны үгийг өргөн ашиглах;
5. Нэр томъёо боловсруулахад бусад монгол хэлнүүдээс үг авч хэрэглэх;
6. Үг хураан товчлох гэх зэрэг зарчмыг багтааж болно.

б) *Харь хэлний нэр томъёог монгол хэлэнд хэрэглэх*

1. Харь хэлний нэр томъёог утгачлан орчуулах;
2. Харь хэлний нэр томъёог хуулбарлан буулгах;
3. Харь хэлний нэр томъёог хэвээр нь зээлдэн авах;
4. Харь хэлнээс зээлдэн авсан үгэнд монгол залгавар залгаж нэр томъёо үүсгэх;
5. Харь үг, монгол нэр томъёо хоёрыг зэрэгцүүлэн уялдуулах;
6. Үг хураан товчлох зэрэг зарчмыг оруулж болно гэжээ.

Монгол нэр томъёо тогтооход өнөөдөр баримталж буй гол зарчим бол:

1. Салбар ухааны нэр томъёог нарийн тогтолцоотой тогтоох;
2. Англи болон англи хэлээр дамжин орж ирж байгаа харь хэлний нэр томъёоны утгвар, дагавар, язгуурыг монгол хэлний тохирох үгтэй нэг мөр болгон оноож авах;
3. Харь хэлний утга учир мөн чанарыг бүрэн гүйцэд ухааран ойлгож монголоор зөв оноох;
4. Монгол хэлний олон зуун нөхцөл залгаврыг нэр томъёо бүтээхэд чадамгай ашиглах (Адьяа, 2003: 55-56) зэрэг болно хэмээн О.Адьяа авч үзсэн буй.


ӨМӨЗО-д Д.Баатар *Монгол хэлний нэр томъёоны судлал* номдоо монгол нэр томъёоны нэрлэх асуудалд дараах зарчмуудыг дэвшүүлсэн буй. Үүнд:

1. Үгсийн сангаа уудлах;
2. Хуучин үгийг сэргээх;
3. Нутгийн үгийг шингээн авах;
4. Шинэ нэр томьёо бүтээх
 - a) Утгазүйн арга;
 - b) Авиазүйн арга;
 - c) Үгзүйн арга;
 - d) Өгүүлбэрзүйн арга
5. Харь хэлний нэр томьёог орчуулах нь
 - a) Махчлан орчуулах;
 - b) Утгачлан орчуулах;
 - c) Дагаварчлан орчуулах
6. Харь хэлнээс нэр томьёо зээлэх зарчим
 - a) Эх хэлэнд байдаг нэр томьёог зээлэхгүй;
 - b) Нутгийн аялгуу ба аман ярианы үгэнд байдаг нэр томьёог зээлэхгүй;
 - c) Эх хэлнийхээ материалыг ашиглан бүтээж болдог нэр томьёог зээлэхгүй;
 - d) Эх хэлээрээ илтгэж(орчуулж) болдог нэр томьёог зээлэхгүй;
 - e) Нэр томьёог дамаар зээлэхгүй
7. Харь хэлнээс нэр томьёо зээлэх арга
 - a) Эгшиг зохицуулах арга;
 - b) Авиа солих арга;
 - c) Авиа нэмэх арга;
 - d) Авиа орхих арга зэрэг болно (Баатар, 2008: 301).

4.1. Харь хэлний нэр томьёог хуулбарлан буулгах зарчмаар үүссэн нэр томьёоны ижил нэр

Өвөр Монголд нэр томьёо оноон тогтоохдоо ихэвчлэн англи, латин хэлний нэр томьёог хятад хэлнээс дамжуулж хуулбарлан буулгахдаа зарим оновчгүй буюу англи, латин хэлэн дэх тухайн нэр томьёоны уг утгаас холдсон зүйл ажиглагдаж байна. Улмаар эндээс адил бус нэр томьёо түүнчлэн ижил нэр томьёо үүсэж байна. Тодруулбал, хятад хэлний 著书编辑, 期刊编辑, 新闻编辑 зэргийн 编辑-ийг цөмөөр нь *найруулагч* хэмээн дүйлгэж, *номын найруулагч, сэтгүүлийн найруулагч, сонин мэдээний найруулагч* хэмээн шууд орчуулан нэрлэж буй. Түүнчлэн 导演 хэмээх нэр томьёог хятад хэлний нөлөөгөөр *кино найруулагч* хэмээн нэрлэлгүй, *удирдан тоглуулах* гэдэг хятад хэлний өнгөц утгад нь суурилан кино *удирдаач* хэмээн үгчлэн хуулбарласнаас ижил нэр үүсэж байна. Хэрэв 导演 гэдгийг хятад хэлэнд 电影编辑 гэж нэрлэсэн тохиолдолд *кино найруулагч* хэмээн орчуулан буулгах нь. Эндээс бид хоёр оронд хуулбарлан буулгах зарчмаар нэр томьёо зохиохдоо монгол хэлний үгийн сангаас өөр өөр үг сонгон дүйлгэснээс ялгаа зөрөө үүсгэж байгааг тогтоож болно. Энэ мэтчилэн ойролцоо утгатай үгээр оноосон байдал нийт үгийн 36%-ийг эзэлнэ. Энэ нь монгол хэлний аялгуу хоорондын үгийн сангийн ялгаа

нь орчуулгад туссанаас үүдсэн шинжтэй байна (Гэрэлмаа, 2018: 67) хэмээн үзсэн байна. Өөрөөр хэлбэл, харь хэлний нэр томъёог орчуулан хуулбарлахдаа хоёр оронд монгол хэлнийхээ адил бус үгээр дүйлгэснээс *найруулагч, удирдаач* мэтийн нэр томъёоны ижил нэр үүссэн байхыг мэдэж болохоор байна. Ингэж үүссэн нэр томъёоны ижил нэрийн утга агуулгыг нягтлан, түүнийг түлхүүр нэр томъёо болгож улмаар салбар шинжлэх ухааны адил бусаар нэрлэж байгаа нэр томъёог мөшгөн хөөж болно. Энэ тухай доорх бүдүүвчээс харна уу.



Зураг 1. Найруулагч хэмээх нэрийн бүдүүвч

4.2. Монгол хэлэнд нэгэнт байсан үгийг шинэ утгаар сэргээн хэрэглэх зарчмаар үүссэн нэр томьёоны ижил нэр

Аливаа хэлний үгийн сангийн утга нь олон янзын арга замаар арвижин баяждаг. Үүнд үгийн утгыг шилжүүлэн хэрэглэх явдал суурь болдог. Утга шилжүүлэн хэрэглэснээр нэгэн үгэнд салаа утга үүсэн хөгждөг юм. Үгийн утга шилжүүлэн хэрэглэхэд тэдгээр юм үзэгдлийн байр байдал, хэлбэр дүрс, гүйцэтгэх үүрэг, өнгө зүс... зэргийн адил төстэй шинжийг анхаарч үздэг байна. Жишээлбэл, онгоц: *малд тэжээл, ус өгөх гонзгой хэлбэртэй хэрэгсэл, сав: мал услах онгоц*; усанд хөвөгч тээврийн хэрэгсэл: *усан онгоц* байснаа хожим далавч бүхий тээврийн нисэх хэрэгсэл *нисэх онгоц* гэх болжээ. Үгийн утга нь нэгэн хэвшмэл байдалд үргэлжид тогтонги байдаг бус, харин нийгмийн хөгжлийг даган хувиран өөрчлөгддөг. Жишээ нь *тариа* гэж орчин цагийн монгол хэлэнд тарьж ургуулах амуу будааны ерөнхий нийтлэг нэр байснаа хожим хүн, амьтны биед зүүтэй тариураар хийдэг эм, вакцин, тарилга аливаа зүйлийг нэрлэх болжээ.

Түүнчлэн монгол хэлэнд нэр томьёо оноон тогтоох гол зарчмын нэг нь нэгэнт байсан үгийг шинэ утгаар сэргээн хэрэглэх зарчим билээ. Шинэ утга оруулах аргад үгийн үндсэн утгад суурилан утга шилжүүлэх болон утга хувиргах арга багтдаг юм. Монголд нэгэнт байсан үгийг шинэ утга оруулах аргаар нэр томьёо оноон тогтоосон нь бага бус, Өвөр Монголд харьцангуй цөөн учир энэ нь хоёр оронд нэр томьёоны ижил нэр үүсгэх нэг шижим болдгийг анзаарч болно. Жишээлбэл, *онгоц* хэмээх ижил нэр нь Монголд шинэ утга: *нисэх онгоц* гэсэн утгатай болсон бол *бичлэг* хэмээх ижил нэр нь Монголд шинэ утга: *соронзон бичлэг, зураг* хэмээх ижил нэр нь шинэ утга: *фото зураг* гэх мэт болсныг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 1. Шинэ утгаар сэргээн хэрэглэсэн ижил нэрийн хүснэгт

Бичлэг	Монгол Улс	Бичлэгийн арга (найруулга дүрслэлийн арга) (Өвөр Монгол: найруулгын арга) соронзон бичлэг (Өвөр Монгол: соронзон дүрс шингээлт)
	Өвөр Монгол	Зөв бичлэгийн дүрэм (Монгол Улс, Өвөр Монгол)
Зураг	Монгол Улс	Зураг авах (Өвөр Монгол: сүүдэр татах), зурагчин (Өвөр Монгол: сүүдэр татах мэргэжилтэн)
	Өвөр Монгол	Зурагчин (Монгол Улс: зураач)
Боловсрол	Монгол Улс	Боловсрол судлал (Өвөр Монгол: сургаан хүмүүжлийн ухаан)
	Өвөр Монгол	Боловсролын дэвтэр (Монгол Улс, ноорог цаас)
Сэтгүүлч	Монгол Улс	Спортын сэтгүүлч (Өвөр Монгол: тамирын сурвалжлагч)
	Өвөр Монгол	Сэтгүүлийн найруулагч (Монгол Улс: редактор)
Ханиад	Монгол Улс	Ханиад томуу (амьсгалын замын цочмог, үрэвсэлт өвчин) (Өвөр Монгол: тагшуур)
	Өвөр Монгол	Ханиах үзэгдэл

Хатгалга	Монгол Улс	Хатгалга өвчин: уушгины хатгаа тусах (Өвөр Монгол: уушгины үрэвсэл)
	Өвөр Монгол	Хавирганы мөгөөрсний үрэвсэл зэрэг сүвээний хавиргаар хатгалах өвчин.
Дүүрэг	Монгол Улс	Сүхбаатар дүүрэг (Өвөр Монгол: тойрог) (Монгол Улс, Өвөр Монгол: тойрог зам)
	Өвөр Монгол	Алс дүүрэг (Монгол Улс, Өвөр Монгол)
Гааль	Монгол Улс	Татвар, хураамж: гааль авах (хил нэвтрэх бараанаас татвар авах), (Өвөр Монгол: боомтын татвар авах), Хил нэвтэрч буй зорчигч, барааг шалгах байгууллага (Өвөр Монгол: боомт)
	Өвөр Монгол	Гааль авах (Монгол Улс: татвар авах)
Онгоц	Монгол Улс	Нисэх онгоц
	Өвөр Монгол	Усны онгоц

Нэгэн зүйлийг нэмж хэлэхэд, Монгол, Өвөр Монголд хэрэглэж байгаа нэр томъёонд ижил нэр томъёо нь уугуул үгсийн ижил нэр, ормол үгсийн ижил нэр ажиглагдаж байна. Мэдээж, нэр томъёо оноон тогтооход уугуул үг үндсэн үүрэг гүйцэтгэдэг. Уугуул үг гэдэг нь аливаа нэг улс үндэстний хэлэнд анхлан хэрэглэж байсан цагаас эхлэн байгаль дэлхий, өөрсдийн соёл, аж ахуй, өдөр тутмын үйл зэрэгтэй холбоотой юм, ухагдахууныг нэрлэж, идэвхтэй хэрэглэж ирсэн үгийн сангийн бүрэлдэхүүн хэсгийг хэлнэ. Ийм учраас хоёр оронд уугуул үгсээр нэрлэн тогтоосон нэр томъёоны ижил нэр харьцангуй олон байдаг билээ. Харин нэр томъёоны ижил нэр нь шинжлэх ухааны салбарт өөр өөр ухагдахууныг нэг нэр томъёогоор илэрхийлэх үзэгдлийг үүсгэж, улмаар үгийн сангийн ялгааг бий болгож байна. Тухайлбал, нийгмийн шинж чанартай харилцаа холбоонд давтамж өндөр байдаг *эдийн засаг* хэмээх ижил нэр нь эдийн засгийн салбар, санхүүгийн салбар, түүнчлэн банк санхүүгийн салбарт ч нөлөөлж, эдгээр салбарын бүхий л хүрээнд нэр томъёоны ялгаа зөрөөг үүсгэж байна. Тодруулбал, *эдийн засаг /economy/*, Монголд *үйлдвэрлэх хүчний хөгжлийн тухайн шатанд тохирч буй үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэлийн харьцааны цогцос*. Энэхүү нэр томъёог Өвөр Монголд *аж ахуй* хэмээн нэрлэдэг. *Аж ахуй* хэмээх нэр томъёо нь Монголд, а. *Нийгмийн ямар нэгэн хэвилийн үйлдвэрлэлийн арга*; б. *Үйлдвэрлэх харилцааны бүгд цогц*; в. *Үйлдвэрлэлд шаардагдах болон үйлдвэрлэлийг бүрэлдүүлэх бүх юм, түүний цогц* г. *Үйлдвэрлэлийн ямар нэгэн төрлийн салбар, нэгж* зэрэг агуулга ухагдахууныг илэрхийлж буй. Жишээ нь, туслах аж ахуй, аж ахуйн нэгж гм. *Туслах аж ахуйг* Өвөр Монголд *туслах аж үйлс, аж ахуйн нэгжийг аж ахуйлал* хэмээн тус тус нэрлэдэг. Ийнхүү *эдийн засаг* хэмээх ижил нэр томъёоноос дахин *аж ахуй* хэмээх ижил нэр томъёо үүсэж, түүнээс хэлбэр өөр өдий төдий нэр томъёо цааш салаалан үүсэж байна.

Харин Өвөр Монголд, *эдийн засаг: улсаас өөрийн үүрэг тушаалаа биелүүлэхийн төлөө, нэг бүлэг нийгмийн үйлтгэхүүний хуваарилалт ба дахин хуваарилалтад оролцох явцын дундаа холбогдол бүхий эл талтай үүсэх аж ахуйн*

харьцаа (1999: 262) ажээ. Гэтэл энэ нэр томьёо нь Монгол улсын *санхүү* гэх нэр томьёотой дүйцэж буй. Үүнээс улбаалан Монголд *банк санхүү* хэмээн хэвшсэн нэр томьёог Өвөр Монголд, *мөнгөн гүйлгээ* гэж нэрлэж хэвшсэн байх ялгааг мэдэж болно. Түүнчлэн банк санхүүгийн салбарын бүх нэр томьёо бүхэлдээ ялгаатай нэрлэгдэнэ.

Мэдээж нэр томьёо бүх нийтийн чанартай. Монголчууд, Өвөр Монголчууд нийгмийн ямар нэг чиглэлээр тухайлбал, утга зохиолын хэлээр ярьж харилцаж байна гэж төсөөлье. Энэ үед тохиолдлоор аль нэгэн салбар шинжлэх ухааны нэр томьёотой тулгарч болно. Энэ мэтчилэн нийгмийн шинж чанартай харилцаа холбооноос адил бус нэр томьёо, нэр томьёоны ижил нэрсийг илрүүлж болох бөгөөд эндээс хоёр орны үгийн сангийн ялгаа, түүнчлэн ухагдахууны зөрүүг мэдэж болно. Ингэж тохиолдлоор тааралдсан нэр томьёоны ижил нэрийн утга, агуулгыг нягтлан, түүнийг түлхүүр нэр томьёо болгож улмаар салбар шинжлэх ухааны адил бусаар нэрлэж байгаа нэр томьёог мөшгөн хөөж болно. Энэ тухай доорх бүдүүвчээс харна уу.



Зураг 2. Эдийн засаг хэмээх нэрийн бүдүүвч

Үүнээс гадна, хоёр орны ахуйн өргөн хэрэглээний нэр томъёонд ормол ижил нэр ажиглагдаж байна. Харь хэлнээс орж ирсэн үг олон утгатай болсон нь цөөн байх бөгөөд олон утгатай болоход нэлээд хугацаа өнгөрч идээшсэний дараа сая олон утгатай болж эхэлдэг байна. Үгийн утга баялаг байх явдал бол уул хэлний үгийн санд өнө удаан хэрэглэгдсэний нэг шинж мөн юм. Ийм төрлийн жишээг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2. Харь гаралтай ижил нэрийн хүснэгт

Жин	Монгол Улс	Жингээ хасах (Өвөр Монгол: турах.)
	Өвөр Монгол	Нэг жин (Монгол Улс: 500 грамм)
Сан	Монгол Улс	Хөгжлийн сан (Өвөр Монгол: хөгжлийн суурь мөнгө)
	Өвөр Монгол	Сангийн гэр (Монгол Улс: агуулах)
Данс	Монгол Улс	Дансны дугаар (Өвөр Монгол: банкны дугаар)
	Өвөр Монгол	Данс үзэх (Монгол Улс: архивын баримт үзэх)
Бийр	Монгол Улс	Бийр, бал, үзгэн бал, тосон бал, шохой (Өвөр Монгол, үсэн бийр, болд бийр, тосон бийр, оогийн бийр)
	Өвөр Монгол	Бийр (Монгол Улс: бал)
Мотор	Монгол Улс	Мотор цохих, мотор асах (Өвөр Монгол: хөдөлгүүр цохих, хөдөлгүүр асах)
	Өвөр Монгол	Дотоод шаталтын хөдөлгүүр бүхий хүнд оврын дугуй, мотор тэрэг (Монгол Улс: мотоцикл)
Авто	Монгол Улс	Авто зам, авто машин, авто сургууль (Өвөр Монгол: засмал зам, машин тэрэг, жолооны сургууль)
	Өвөр Монгол	Авто хадгалах, авто явган буу (Монгол Улс: автомат хадгалах, автомат буу)
Норм	Монгол Улс	Журамласан хэм хэмжээ (Өвөр Монгол: Баримжаа, дүрэм тогтоол)
	Өвөр Монгол	Өдрийн норм (Монгол Улс, Өвөр Монгол)

5. Дүгнэлт

Монгол, Өвөр Монголын үгсийн сангийн ижил нэрийн талаарх жишээ баримтад тулгуурлан авч үзэхэд нэгдүгээрт, нэр томъёоны ижил нэрийн жишээнээс түүний үүссэн шалтгааныг хялбар тогтоож болохоор байна. Нэгдүгээрт, харь хэлний нэр томъёог хуулбарлан буулгахдаа хоёр оронд монгол хэлнийхээ адил бус үгээр дүйлгэснээс *найруулагч*, *удирдаач* мэтийн нэр томъёоны ижил нэр үүссэн байхыг мэдэж болохоор байна. Нөгөө талаар, Монголд монгол хэлний үгийн санд өмнө нь байсан үгийг нэр томъёонд шинэ утгаар хэрэглэсэн тохиолдолд ижил нэр үүсэж байгааг зураг (шинэ утга: фото зураг) , бичлэг (шинэ утга: соронзон бичлэг) гэх мэт жишээнээс харж болно.

Хоёрдугаарт Монгол, Өвөр Монголд хэрэглэж байгаа нэр томъёоны ижил нэр нь өөр өөр ухагдахууныг нэг нэр томъёогоор илэрхийлэх үзэгдлийг үүсгэх гол сурвалж болж байгааг харж болно.

Гуравдугаарт нэр томъёоны тогтолцоонд ижил нэрийг гурван төрөлд авч үзэж болохоор байна. Нэгдүгээрт нэг нэр томъёо өөр өөр салбарын ухагдахууныг тэмдэглэснийг шинжлэх ухааны салбар хоорондын ижил нэр гэнэ. Хоёрдугаарт утга зохиолын хэлний үгийн утгыг нэр томъёоны хүрээнд зүйрлэн нэрлэдгийг утга зохиолын хэл болон нэр томъёоны хоорондын ижил нэр гэдэг. Гуравдугаарт Монгол, Өвөр Монголын үгсийн санд салбар шинжлэх ухаан дотроо нэг нэр томъёогоор адил бус ухагдахууныг илэрхийлдгийг аялгуу хоорондын ижил нэр хэмээн үзэж болохоор байна.

Ном зүй


- Адьяа, О.** (2000). *Орос, монгол нэр томъёоны бүтэц-утга зүйн харьцуулсан судалгаа* (XX зууны сүүлчийн 70-80 жилийн хэрэглэгдэхүүнд тулгуурлав). *хэл бичгийн ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон зохиолын хураангуй*. Улаанбаатар, 2000: 15-16. [Adiya, O. *Oros, mongol ner tomionii бүтэц-утгазүйн харitsuulsan sudalгаа* (XX zuunii сүүлчийн 70-80 jiliin hereglegdehүүнд тулгуurlaw) [A Comparative Study of the Structure and Semantics of Russian and Mongolian Terms (Based on the Usage of the last 70-80 years of the 20th century)]. Ulaanbaatar, 2000: 15-16.]
- Жамбалсүрэн, Г., Дондуков, У.И., Сумьяабаатар, Б.** (1990). *Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс*. Хөххот: ӨМСХ-ийн хороо. [Jambalsüren, G., Dondukow, U.I., Sumiyabaatar, B. *Orchin tsagiin mongol helnii үгсийн сангийн судлалын үндэс* [Basics of Modern Mongolian Lexicology]. Hohhot: Inner Mongolian Education Press. 1990.]
- Төмөрцэрэн, Ж.** (2004). *Монгол хэлний үгсийн сангийн судлал*. ӨМСХ-ийн хороо, Хөххот, 2004:48. [Tömörtseren, J. *Mongol helnii үгсийн сангийн судлал* [Mongolian Lexicology]. Hohhot: Inner Mongolian Education Press. 2004.]
- Гэрэлмаа, Г.** (2020). *Монгол хэлний нэр томъёо бүтэх нийлэг болон задлаг хэв шинж*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Gerelmaa, G. *Mongol helnii ner tomio бүтэх задлаг болон нийлэг хэв шинж* [Analytic and Synthetic Methods of Creating Terms in Mongolian]. Ulaanbaatar: Soyombo printing. 2020.]
- Гэрэлмаа, Г.** (2018). Монгол хэлний шинэ үгийн үүсэл, харилцан нөлөөллийн асуудалд. *Хэл зохиол судлал*, XI(43):62-72. [Gerelmaa, G. The Formation and Interaction of Mongolian Neologism. *Hel zohiol судлал*, 2018, XI (43): 62-72.]
- Догсүрэн, Ч.** (1988). *Монгол нэр томъёо оноох, толилох, жигдлэх асуудалд*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэх үйлдвэр. [Dogsüren, Ch. *Mongol ner tomio оноох, толилох, жигдлэх асуудалд* [On the Issues of Creating, Processing, Harmonizing Mongolian Terms]. Ulaanbaatar: Printing of Mongolian Academia of Science. 1988.]
- Норжин, Ц., Мөрөн, М.** (1999). *Монгол хэлний толь*. Хөххот: ӨМАХХ. [Norjin, Ts., Mürün, M. *Mongol helnii toli* [Mongolian Dictionary]. Hohhot: ӨМАНН. 1999.]
- ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн.** (2008) *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь*. MAS. *Mongol helnii delgerengüi тайлбар толь* [A Comprehensive Mongolian Dictionary]. <http://www.mongoltoli.mn>.]

МУШУА. *Шинжлэх ухааны түлхүүр нэр томъёоны тайлбар толь.* [MAS. *Shinjeleh uhaany tülhüür ner tomïyonii tailbar toli* [Dictionary of Scientific Key Terms] <http://www.dict.ac.mn/>.]

Баатар, Д. (2008). *Монгол хэлний нэр томъёоны судлал.* Хөххот: ӨМАХХ-ийн хороо. [Baatar. *Mongol helnii ner tomïoony sudlal* [Terminology of the Mongolian language]. Beijing: The People’s Publishing House. 2008.]

Лю Юэ. (2020). *Хэл шинжлэлийн онолын өргөн хэрэглээний нэр томъёог харьцуулал.* Хөххот: ӨМАХХ-ийн хороо. [Liu Yue. *Hel shinjeleliin onolyn örgön heregleenii ner tomïyonii haritsuulal* [Comparison of Widely Used Terms in Linguistic Theory]. Huhhot: Inner Mongolian People’s Publishing House. 2020.]

Адьяа, О. (2003). Монгол нэр томъёо тогтоож ирсэн гол гол зарчим. *Монгол хэл бичиг, 1:* 55-56. [The Main Principles for Mongolian Term Formation. *Mongol hel bichig, 2003, 1:* 55-56.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.